



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/173


Есөнбулаг

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн А.Бямбадорж ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/139 дугаартай Есөнбулаг сумын спорт заалны барилга угсралтын ажлын (үргэлжлүүлэх) гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай Үнэлгээний хороо байгуулах тухай захирамжийн 1 дүгээр заалтад “Үнэлгээний хорооны нарийн бичиг (А.Бямбадорж) гэснийг “Үнэлгээний хорооны нарийн бичиг (Ч.Мэндбаяр) болгон өөрчилсүгэй.

2.Холбогдох хууль, журамд нийцүүлэн тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Ж.Амгаланбаатар)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

